

МОНГОЛ ХҮҮХДИЙН АВЬЯАС ЧАДАМЖИЙН УРЬТАЛ СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ХЭТИЙН ТӨЛӨВ

Ж. Нямаа

Доктор (Ph. D.), дэд профессор

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

nyamaa12345@must.edu.mn

Хураангуй: Тус судалгааны ажилд баруун, зүүн, төв, хангайн бүсийн болон Улаанбаатар хотын ЕБС-д суралцаж байгаа I-XI ангийн 86640 сурагчдын хэл өгүүлэхүйн; логик-математикийн; хөдөлгөөн-тэнцвэрийн; хүмүүс хоорондын харилцааны; дотогшоо төвлөрөх; байгаль, ан амьтныг хайрлах; хараа-орон зайн; хэмнэл-сонсголын чадамжийн хөгжлийн түвшинг тогтоож, бүс нэг бүрийн сурагчдын давамгайлан илэрч байгаа болон сул илэрч байгаа чадамжууд, тэдний насны хөдлөл зүйг тодорхойллоо.

Түлхүүр үг: Авьяас, чадамж, хэл өгүүлэхүйн чадамж, логик-математик чадамж, хөдөлгөөн-тэнцвэрийн чадамж, хүмүүс хоорондын харилцааны чадамж, дотогшоо төвлөрөх чадамж, байгаль, ан амьтныг хайрлах чадамж, хараа-орон зайн чадамж, хэмнэл-сонсголын чадамж

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газар 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө: "... эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн "Зөв монгол хүүхэд" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ", "ерөнхий боловсролын сургалтад хүүхэд бүрийг хөгжүүлэх бодлого баримтлан, үндэсний шинэ стандарт нэвтрүүлнэ" гэж тус тус заасан байна.

2013 оны 08-р сарын 16-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар монгол хүүхэд бүрийг нээлттэй, өрсөлдөөнтэй, мэдээлэлжсэн орчинд амьдрах чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах,

хамтран ажиллаж амьдрах, насан туршдаа суралцах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болгож төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлсэн "Зөв монгол хүүхэд" үндэсний хөтөлбөрийг баталжээ.

Тус хөтөлбөрийн хүрээнд монгол хүүхдийн хөгжил, төлөвшлийн талаар Монгол улсын засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн нэг нь "Авьяас" дэд хөтөлбөр юм.

Тус дэд хөтөлбөрийн хүрээнд

- Монгол хүүхдийг хөгжлийн суурь судалгааг хийж, хөгжлийн шалгуур үзүүлэлтийг гаргах;

- Хүүхдийн авьяасыг бүх талаар нээх, хөгжүүлэх, амжилтад

хүргэх арга зүйг боловсруулж, түгээх;

- Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчин бүрдүүлж, багш, эцэг эх, олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

- Бага наснаас нь хүүхэд бүрийн авьяас, чадварыг нээн хөгжүүлснээр ирээдүйн ажил, мэргэжлээ зөв сонгох, эзэмшсэн мэргэжлээрээ үр бүтээлтэй хөдөлмөрлөх цогц мэдлэг, чадвартай иргэн болж төлөвших нөхцөл бололцоог бүрдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлжээ.

Дэвшүүлсэн эдгээр зорилтуудад хүрэхийн тулд юуны өмнө хүүхэд нэг бүрийн авьяасыг нээн илрүүлж, түүнийг цааш хөгжүүлэх арга замыг тодорхойлох явдал чухал юм.

Хүүхдийн авьяасыг судалж буй гадаадын нэр хүндтэй судлаачид ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 80 гаруй хувь нь ямар авьяас чадвартай болохоо сайн мэддэггүй, сургалтын явцад суралцах чадвар бүрэн эзэмшээгүй болохыг өөрсдийн явуулсан туршилт судалгаагаараа тогтоосон байна [Шадриков В.Д., 2010].

Манай улсын хувьд монгол хүүхдийн авьяасын сэтгэл зүйн бүтэц, тархац, хөгжлийн түвшинг дорвитой судлаагүй, монгол хүүхдийн авьяасыг хөгжүүлэх технологийг бүрэн боловсруулаагүй байна.

Хүүхдийн авьяас, чадамжийг илрүүлж, түүнийг гүйцэтгэх үйл ажиллагаатай нь ухамсарлуулан холбож өгөх нь хүүхэд өөрийгөө танин мэдэх, өөрийн бодит бололцоогоо хөгжүүлэх, нийгмийн бүрэн эрхт, бүтээлч гишүүн болж, нийгмийн баялагийг бий болгоход үнэлж баршгүй ач холбогдолтой.

Сүүлийн хорин жилийн хугацаанд суралцагсдын авьяасын онцлогийг нээн илрүүлэх, хөгжүүлэх, тэдний авьяасын онцлог дээр тулгуурлан мэргэжлийн чиг баримжаа олгох асуудлыг олон шинжлэх ухааны эрдэмтэд, түүний дотор сэтгэл судлаачид ихээхэн анхааран судалжээ. Үүний нэг илрэл бол боловсролын салбарт хэрэгжүүлж буй энэ чиглэлийн судалгаа, төсөл, хөтөлбөр юм. Тухайлбал 1996 онд ЮНЕСКО-ийн санхүүжилтээр “Боловсролыг бүх нийтийн хүртээл болгох” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн “Хүмүүсийн авьяас сонирхлыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”, 2003 онд хэрэгжүүлсэн “Монголын өсвөр үеийнхний аж байдлыг сайжруулах нь” төсөл, 2010 онд хэрэгжүүлсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын авьяас чадварыг нээн илрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Карьерийн баримжааг хөгжүүлэх нь” судалгаа, 2011 онд Нийслэлийн хөдөлмөрийн газар, Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвөлгөө аян”, “Ажил, мэргэжлийн

зөвлөх” бэлтгэх цуврал сургалт”, Хөдөлмөрийн төв биржийн “Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа” зэрэг олон ажлуудыг дурдаж болох юм.

Эдгээр судалгааны ажилуудад хүүхдүүдийн авьяас чадварын асуудлыг авьяасын талаарх орчин үеийн онолын үүднээс авч үзээгүй, судалгааны түүврийн хэмжээ хязгаарлагдмал, туршилт судалгаагаар гарган авсан үр дүнд чанарын анализ хийгээгүй зэрэг сул тал ажиглагдаж байна.

Иймд бид дээрх судалгааны ажлуудын нийтлэг дутагдалтай талуудыг нөхөх үүднээс “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын авьяасын онцлог” сэдэвт инновацийн төслийн хүрээнд монгол сурагчдын авьяасын онцлог, түүний хөгжлийн түвшинг урьдчилсан байдлаар тогтоох улмаар сурагчдын авьяасыг хөгжүүлэх арга замыг боловсруулах оролдогыг хийхийг зорьсон юм.

Тус судалгааны ажлын үр дүнг авч үзэхийн өмнө авьяас, түүний мөн чанар, хөгжлийн түвшин, нөлөөлөх хүчин зүйлийн талаар цухас авч үзэх нь зүйтэй.

Авьяасын сэтгэл зүйн асуудал эрдэмтэд, сэтгэгчдийн анхаарлыг олон зууны турш татаж ирсэн боловч одоог болтол түүний мөн чанарын талаар нэгдмэл үзэл, хандлага үгүй байна. Судлаачдын үзэж байгаагаар авьяасын асуудлыг ХХ зууны 30-аад оны үед оросын сэтгэл судлаач Б.М. Теплов нилээд нухацтай авч үзжээ. Тэрээр

сэтгэцийн бусад категориос авьяасын ялгагдах шинжийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: Авьяас бол

- нэг хүнийг нөгөө хүнээс ялгаж буй сэтгэл зүйн хувийн онцлог


- үйл ажиллагааны амжилтад нөлөөлөх хувийн онцлог

- тухайн хүнд төлөвшин тогтсон мэдлэг, чадвар, дадал биш [Теплов, 1985].

Орчин үеийн судлаачид Б.М. Тепловын авьяасын 3 онцлог шинж авьяас гэж чухам юуг хэлэх вэ ? гэсэн асуултад бүрэн хариулт өгч чадахгүй байгааг онцлон тэмдэглэж байна [Шадриков, 2010].

Авьяасын мөн чанарыг тодорхойлох асуудлыг нэн амжилттай шийдвэрлэж байгаа судалгааны нэг чиглэл бол авьяасын нейропсихологийн хандлага юм. Энэ хандлагын төлөөлөгчид авьяас нь тухайлбал зурж дүрслэх юмуу дуулах, бүжиглэх авьяас нь тархины олон бүсүүдийн хамтын үйл ажиллагааны үр дүн гэж үзэж байна. Тэдний судалгаагаар ярих өгүүлэх үйл ажиллагаанд 7 болон түүнээс дээш бүсүүд оролцдог болохыг баталжээ [Eckermann L., 2005] (Зураг 1-ийг үзнэ үү).

Зураг 1. Авьяас, тархины бүс



Авьяасын сэтгэл зүйн судалгааны өөр нэг чиглэл бол авьяасын сэтгэц хэмжилтийн хэмээх чиглэл юм. Энэ чиглэлийг баримтлагчид авьяас бол IQ-ээр илэрхийлэгддэг хэмжигдэхүүн гэсэн үзлийг дэвшүүлж, хүнтэй харилцах IQ, логик-математикийн IQ, дуу хөгжмийн IQ, бие бялдар-хөдөлгөөний IQ гэх мэт олон IQ-г цогц байдлаар тогтоох замаар хувь хүний авьяасыг илрүүлж, үнэлж болно гэж үздэг [Lynn R., 2001].

Авьяасын сэтгэл зүйн судалгааны ирээдүйтэй гэж тооцогдож байгаа чиглэлийн нэг бол авьяасыг хувь хүний чадамж, нөөц гэх үзэл дээр суурилсан чиглэл юм. Энэ чиглэлийн эрдэмтэд хүний гүйцэтгэж буй үйл ажиллагаа, төрөл, тавигдаж буй шаардлагын нөлөөгөөр хувь хүний чадвар, нөөц **оператив** (шалмаг, түргэн) шинжтэй болж, энэ нь төрөл бүрийн тусгай авьяасын үндэс болно гэж үздэг. Энэхүү хандлагатай нийцүүлэн авьяасыг

- чадваргүй,
- чадвартай,
- чадварлаг,
- чадмаг,
- чадамгай гэх зэргээр

ангилан үзэж болохоор байна.

Авьяасын дээрх чиглэлийн үзэл баримтлалтай төстэй чиглэл бол америкийн сэтгэл судлаач Х. Гарднерийн боловсруулсан олон талт оюун ухааны онол юм.

Х. Гарднер хүний оюун ухаан нь бие даасан тусгай чадамжуудаас бүтдэг цогцолбор

зүйл юм гэсэн үзэл баримтлалыг 1980-аад оны дунд үеэр дэвшүүлжээ. Тэрээр оюун ухаан гэдэг нь бие даасан өөр өөр чадамжийг агуулна. Эдгээр нь нь бие даасан өөр өөрийн гэсэн онцлог бүхий хэв шинжүүдийг үүсгэдэг. Хэв шинж тус бүр нь нэг хүнд заавал жигд хөгжсөн байх албагүй. Нэг юм уу, хоёр шинж түлхүү, бусад нь ердийн төвшинд хөгжсөн байдаг. Оюун ухааны аль хэв шинж нь давамгайлж байгаагаас шалтгаалан амьдралд зохицон дасгах чадвар нь хүн хүний хувьд харилцан адилгүй аргаар явагддаг гэж үзэж байв [Gardner H., 1983].

Х. Гарднерийн онол сургалтын явцад суралцагчдын оюун ухааны хөгжлийн хувийн онцлог, хэв шинжийг илрүүлэн хөгжүүлэх нь чухал гэж үздэг хүмүүнлэг онол учраас өнөөдөр дэлхийн олон орнуудад өндрөөр үнэлэгдэж, сэтгэл судлаачдын практик үйл ажиллагаанд өргөнөөр ашиглагдаж байна.

Тиймээс бид авьяас чадварын сэтгэл зүйн нэрт эрдэмтэн Х. Гарднерын зохиож, дэлхийн олон орны хүүхдүүдийн авьяасыг үнэлэхэд туршиж үзсэн тус аргыг түшиглэсэн аргыг боловсруулж, судалгаа явуулахыг оролдсон юм.

Судалгааны зорилго: ЕБС-д суралцаж буй сурагчдын авьяасын хөгжлийн түвшин, онцлогийг урьтал байдлаар тогтоох

Судалгааны арга: Америкийн сэтгэл судлаач Х.

Гарднерийн боловсруулсан баруун, төв, хангайн бүсийн 84 хүүхдийн чадамжийн хөгжлийн сургуулийн 86640 сурагч, тэдний түвшинг тодорхойлох сорилын 173280 эцэг эх, багш, нийт 259920 монгол хувилбар хүн хамрагдав (Хүснэгт 1).

Судалгааны хамарсан хүрээ:
Улаанбаатар хот болон зүүн,

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагчдын тооны харьцаа

Д/д	Бүс / Хот	Суралцагсдын тоо	Хувь
1.	Баруун	3207	3,85 %
2.	Зүүн	51672	62,1 %
3.	Төв	4243	11,4 %
4.	Хангай	7416	8,92 %
5.	Улаанбаатар	20102	24,2 %
	Бүгд	86640	100,0 %

Судалгааны үр дүн: боловсролын сургуулийн I-XI Судалгаанд хамрагдсан зүүн, ангийн сурагчдын авьяасын баруун, төв, хангайн бүсийн болон хөгжлийн түвшинг судалж үзэв Улаанбаатар хотын ерөнхий (Хүснэгт 2-4).

Хүснэгт 2. Бага ангийн сурагчдын чадамжийн үзүүлэлтүүдийг бүс нутгаар харьцуулсан нь

Д/д	Судалгааны бүлэг	Чадамжийн төрлүүд							
		Хэл	Мат.	Хөг.	Хөд.	Зур.	Хар.	Дот.	Бай.
1.	Баруун бүс	8,2	7,9	7,3	7,5	8,0	8,2	7,5	7,9
2.	Зүүн бүс	7,9	7,5	7,3	7,4	7,7	8,1	7,5	7,6
3.	Төвийн бүс	8,0	7,3	7,2	7,5	7,6	7,9	7,1	6,9
4.	Хангайн бүс	8,0	7,4	7,2	7,3	7,6	8,0	7,3	7,8
5.	Улаанбаатар	7,6	7,3	6,8	7,2	7,5	7,6	7,1	7,0

Хүснэгт 3. Дунд ангийн сурагчдын чадамжийн үзүүлэлтүүдийг бүс нутгаар харьцуулсан нь

Д/д	Судалгааны бүлэг	Чадамжийн төрлүүд							
		Хэл	Мат.	Хөг.	Хөд.	Зур.	Хар.	Дот.	Бай.
1.	Баруун бүс	7,5	7,7	6,7	7,5	7,2	7,4	6,9	7,4
2.	Зүүн бүс	7,0	7,0	6,5	7,0	7,2	7,1	6,6	6,9
3.	Төвийн бүс	7,2	7,1	6,7	7,2	7,3	7,3	6,8	7,0
4.	Хангайн бүс	7,4	7,1	6,7	7,0	7,2	7,0	6,6	6,8
5.	Улаанбаатар	7,0	7,0	6,5	6,9	7,1	7,0	6,7	6,6

Хүснэгт 4. Ахлах ангийн сурагчдын чадамжийн үзүүлэлтүүдийг бүс нутгаар харьцуулсан нь

Д/д	Судалгааны бүлэг	Чадамжийн төрлүүд							
		Хэл	Мат.	Хөг.	Хөд.	Зур.	Хар.	Дот.	Бай.
1.	Баруун бүс	7,7	7,9	6,4	7,6	7,5	7,8	6,9	7,6
2.	Зүүн бүс	6,9	6,9	5,9	7,0	6,5	7,4	6,3	6,3
3.	Төвийн бүс	7,0	6,9	5,8	7,2	6,6	7,6	6,8	6,3
4.	Хангайн бүс	7,2	7,0	6,3	6,8	6,6	7,2	6,8	6,7
5.	Улаанбаатар	7,0	7,0	6,4	7,2	6,9	7,5	6,9	6,2

Хүснэгт 5-аас үзвэл бидний судалгаанд хамрагдсан баруун, зүүн, төв, хангайн бүсийн болон Улаанбаатар хотын бага ангийн сурагчдад бусадтай харилцаа холбоо тогтоох, харилцаанд өөрийн байр суурийг зөв тодорхойлох, бусдын арга эвийг олж харилцах чадамж, санаа бодол, өөрийгөө үгээр зөв илэрхийлэх, найруулан бичих чадамж, зурж дүрслэх, уран зургийг ойлгох, түүнийг уран сайхнаар илэрхийлэх чадамж, логик-математик тооцоолол хийх чадамж, ан амьтныг хайрлах,

арчлах чадамжууд тэдний бусад чадамжуудаас илүү тод, давамгай мөн нийтлэг илэрч байгаа бол баруун, зүүн, төв, хангайн бүсийн болон Улаанбаатар хотын бага ангийн сурагчдад ая аялгуу, дуу хөгжмийг ойлгох чадамж болон дотроо бясалгах, дотогшоогоо төвлөрөх чадамж, баруун, зүүн, хангайн бүсийн бага ангийн сурагчдад хөдөлгөөний эвсэл, төвийн бүсийн сурагчдад логик-математик тооцоолол хийх чадамж тус тус сул илэрч байна.

Хүснэгт 5. Бага ангийн сурагчдын чадамжийн илрэл

Д/д	Бүс / Хот	Давамгайлан илэрч буй чадамж	Сул илэрч буй чадамж
1.	Баруун бүс	Харилцаа холбоо тогтоох; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Зурж дүрслэх; Логик-математик тооцоо хийх; Ан амьтныг хайрлах.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Хөдөлгөөн; Дотроо бясалгах.
2.	Зүүн бүс	Харилцаа холбоо тогтоох; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Зурж дүрслэх; Ан амьтныг хайрлах; Логик-математик тооцоо хийх.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Хөдөлгөөн; Дотроо бясалгах.
3.	Төвийн бүс	Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Харилцаа холбоо тогтоох; Зурж дүрслэх; Хөдөлгөөний эвсэл; Дуу хөгжмийг ойлгох, мэдрэх.	Дотроо бясалгах; Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Логик-математик тооцоо.
4.	Хангайн бүс	Харилцаа холбоо тогтоох; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Ан амьтныг хайрлах; Зурж дүрслэх; Логик-математик тооцоо хийх.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Хөдөлгөөн; Дотроо бясалгах.
5.	Улаанбаатар хот	Харилцаа холбоо тогтоох; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Зурж дүрслэх; Логик-математик тооцоо хийх; Дотроо бясалгах, дотроо төвлөрөх.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Ан амьтан хайрлах; Дотроо бясалгах.

Баруун бүсийн үгээр илэрхийлэх, найруулан сургуулиудын дунд ангийн бичих; бусадтай харилцаа тогтоох, сурагчдад тэдний чадамжуудаас ан амьтныг хайрлах чадамжууд логик-математик тооцоолол хийх; илүү тод илэрч байгаа бол зүүн хөдөлгөөний эвсэл, санаа бодлоо бүсийн сургуулиудын дунд ангийн

сурагчдад зурж дүрслэх; бусадтай харилцаа холбоо тогтоох; логик-математик тооцоолол хийх; санаа бодлоо үгээр илэрхийлэх, найруулан бичих; хөдөлгөөний чадамжууд, төвийн бүсийн сургуулиудын дунд ангийн сурагчдад бусадтай харилцаа холбоо тогтоох; зурж дүрслэх; санаа бодлоо үгээр илэрхийлэх, найруулж бичих; хөдөлгөөний эвсэл; логик-математик тооцоолол хийх чадамжууд, хангайн бүсийн сургуулиудын дунд ангийн сурагчдад санаа бодлоо үгээр илэрхийлэх, найруулан бичих; зурж дүрслэх; логик-математик тооцоолол хийх; бусадтай харилцаа холбоо тогтоох; хөдөлгөөний чадамжууд, Улаанбаатар хотын сургуулиудын дунд ангийн сурагчдад зурж дүрслэх; бусадтай харилцаа холбоо тогтоох; санаа бодлоо үгээр илэрхийлэх, найруулж бичих; логик-математик тооцоолол хийх; хөдөлгөөний чадамжууд тус тус тэдний бусад чадамжаас нь илүү тод, давамгай илэрч байна.

Баруун бүсийн сургуулиудын дунд ангийн сурагчдад дуу хөгжим, ая аялгууг мэдрэх, ойлгох; дотроо бясалгах, дотогшоогоо төвлөрөх; зурж дүрслэх чадамжууд сул илэрч байгаа бол зүүн бүсийн сургуулиудын дунд ангийн сурагчдад дуу хөгжим, ая аялгууг мэдрэх, ойлгох; дотроо бясалгах, дотогшоогоо төвлөрөх; ан амьтныг хайрлах, арчлах чадамжууд, төвийн бүсийн сургуулиудын дунд ангийн сурагчдад дуу хөгжим, ая аялгууг мэдрэх, ойлгох; дотроо бясалгах, дотогшоогоо төвлөрөх; ан амьтныг хайрлах; хангайн бүсийн сургуулиудын дунд ангийн сурагчдад дотроо бясалгах, дотогшоогоо төвлөрөх; дуу хөгжим, ая аялгууг мэдрэх, ойлгох; ан амьтныг хайрлах, Улаанбаатар хотын сургуулиудын дунд ангийн сурагчдад дуу хөгжим, ая аялгууг мэдрэх, ойлгох; ан амьтныг хайрлах; дотроо бясалгах, дотогшоогоо төвлөрөх чадамжууд тус тус сул илэрч байна (Хүснэгт 6-ыг үзнэ үү).

Хүснэгт 6. Дунд ангийн сурагчдын чадамжийн илрэл

Д/д	Бүс / Хот	Давамгайлан илэрч буй чадамж	Сул илэрч буй чадамж
1.	Баруун бүс	Логик-математик тооцоо хийх; Хөдөлгөөний эвсэл; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Бусадтай харилцаа тогтоох; Ан амьтныг хайрлах.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Дотроо бясалгах; Зурж дүрслэх.
2.	Зүүн бүс	Зурж дүрслэх; Бусадтай харилцаа тогтоох; Логик-математик тооцоо хийх; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Хөдөлгөөний эвсэл.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Дотроо бясалгах; Ан амьтныг хайрлах.
3.	Төвийн бүс	Бусадтай харилцаа тогтоох; Зурж дүрслэх;	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Дотроо бясалгах;

		Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Хөдөлгөөний эвсэл; Логик-математик тооцоо хийх.	Ан амьтныг хайрлах.
4.	Хангайн бүс	Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Зурж дүрслэх; Логик-математик тооцоо хийх; Бусадтай харилцаа тогтоох; Хөдөлгөөний эвсэл.	Дотроо бясалгах; Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Ан амьтныг хайрлах.
5.	Улаанбаатар хот	Зурж дүрслэх; Бусадтай харилцаа тогтоох; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Логик-математик тооцоо хийх.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Ан амьтныг хайрлах; Дотроо бясалгах.

Баруун бүсийн чадамж; логик-математик сургуулиудын ахлах ангийн тооцоолол хийх чадамж; дотроо сурагчдад бидний судалгаагаар бясалгах, дотогшоо төвлөрөх логик-математик тооцоолол хийх чадамж, хангайн бүсийн чадамж; бусадтай харилцаа холбоо сургуулиудын ахлах ангийн тогтоох чадамж; санаа бодлоо үгээр сурагчдад бусадтай харилцаа илэрхийлэх чадамж; хөдөлгөөний холбоо тогтоох чадамж; санаа чадамж; ан амьтныг хайрлах, бодлоо үгээр илэрхийлэх, арчлах чадамж илүү давамгайл илэрч найруулан бичих; логик-математик байгаа бол зүүн бүсийн тооцоолол хийх чадамж; сургуулиудын ахлах ангийн хөдөлгөөний чадамж; ан амьтныг сурагчдад бусадтай харилцаа хайрлах чадамж, Улаанбаатар хотын сургуулиудын ахлах ангийн сурагчдад бусадтай харилцаа холбоо тогтоох чадамж; хөдөлгөөний чадамж; санаа бодлоо үгээр илэрхийлэх чадамж; логик-математик тооцоолол хийх чадамж; зурж дүрслэх чадамж, төвийн үгээр илэрхийлэх чадамж; логик-бүсийн сургуулиудын ахлах ангийн математик тооцоолол хийх чадамж; сурагчдад бусадтай харилцаа дотроо бясалгах, дотогшоогоо холбоо тогтоох чадамж; хөдөлгөөний төвлөрөх чадамжууд тус тус илүү чадамж; санаа бодлоо үгээр тод, давамгайлан илэрч байна илэрхийлэх, найруулан бичих (Хүснэгт 7-г үзнэ үү).


Хүснэгт 7. Ахлах ангийн сурагчдын чадамжийн илрэл

Д/д	Бүс / Хот	Давамгайлан илэрч буй чадамж	Сул илэрч буй чадамж
1.	Баруун бүс	Логик-математик тооцоо хийх; Бусадтай харилцаа тогтоох; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Хөдөлгөөний эвсэл; Ан амьтныг хайрлах.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Дотроо бясалгах; Зурж дүрслэх.
2.	Зүүн бүс	Бусадтай харилцаа тогтоох; Хөдөлгөөний эвсэл;	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх;

		Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Логик-математик тооцоо хийх; Зурж дүрслэх.	Дотроо бясалгах; Ан амьтныг хайрлах.
3.	Төвийн бүс	Бусадтай харилцаа тогтоох; Хөдөлгөөний эвсэл; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Логик-математик тооцоо хийх; Дотроо бясалгах.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Зурж дүрслэх; Ан амьтныг хайрлах.
4.	Хангайн бүс	Бусадтай харилцаа тогтоох; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Логик-математик тооцоо хийх; Хөдөлгөөний эвсэл; Ан амьтныг хайрлах.	Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Зурж дүрслэх; Ан амьтныг хайрлах.
5.	Улаанбаатар хот	Бусадтай харилцаа тогтоох; Хөдөлгөөний эвсэл; Санаа бодлоо үгээр илэрхийлэх; Логик-математик тооцоо хийх; Дотроо бясалгах.	Ан амьтныг хайрлах; Дуу хөгжим, ая аялгууг ойлгох, мэдрэх; Зурж дүрслэх.

Бүдүүвч 1-д дүрслэгдсэн бус байна. Энэ нь сургуулийн бага графикаас үзвэл баруун, зүүн, төв, ангийн насанд чадамжуудын хангайн бүсийн болоод эрчимтэй хөгжил явагддаггүй Улаанбаатар хотын сургуулиудын болохыг илтгэж буй хэрэг юм бага ангийн сурагчдын чадамжийн (бүдүүвч 1-ийг үзнэ үү). үзүүлэлтүүдийн далайц төдийлөн их

Бүдүүвч 1. Бага ангийн сурагчдын чадамжийн үзүүлэлтүүдийг бүс нутгаар харьцуулсан нь




Бүдүүвч 2-оос үзвэл тооцоолол хийх чадамж, судалгаанд хамрагдсан баруун, хөдөлгөөний чадамж, бусадтай зүүн, төв, хангайн бүсийн болоод харилцаа холбоо тогтоох, тэдний Улаанбаатар хотын сургуулиудын арга эвийг олж харилцах, дунд ангийн сурагчдын чадамжийн харилцааны явцад өөрийн байр үзүүлэлтүүд ялангуяа санаа бодлоо суурийг зөв тодорхойлох чадамж, үгээр илэрхийлэх, найруулж бичих ургамал, ан амьтныг хайрлах, чадамж, логик-математик арчлах, байгалийн элдэв үзэгдлийн

мөн чанар, холбоо уялдааг олох, танин мэдэх гэсэн чадамжуудын үзүүлэлтүүд ихээхэн далайцтай байна. Энэ нь сургуулийн дунд ангийн насанд хүүхдүүдийн олон

чадамж эрчимжиж, хөгжиж эхэлдэгийг харуулж байгаа хэрэг юм гэж бид үзэж байна (Бүдүүвч 2-ыг үзнэ үү).


Бүдүүвч 2. Дунд ангийн сурагчдын чадамжийн үзүүлэлтүүдийг бүс нутгаар харьцуулсан нь



Бүдүүвч 3-аас үзвэл ахлах ангийн сурагчдын санаа бодлоо үгээр илэрхийлэх, найруулан бичих; логик-математик тооцоолол хийх; ая аялгуу, дуу хөгжмийг ойлгох, мэдрэх; хөдөлгөөний чадамж; зурж дүрслэх; бусадтай харилцаа холбоо тогтоох; дотроо бясалгах, дотогшоогоо төвлөрөх; ан амьтныг хайрлах, арчлах гэсэн

чадамжуудын үзүүлэлтүүдийн далайц дунд ангийн сурагчдын чадамжуудын үзүүлэлтүүдийн далайцтай харьцуулбал төдийлөн их биш байна. Энэ нь сургуулийн ахлах ангид сурагчдын чадамжуудын эрчимтэй хөгжил саардаг гэж үзэхэд хүргэж байна (Бүдүүвч 3-ыг үзнэ үү).

Бүдүүвч 3. Ахлах ангийн сурагчдын чадамжийн үзүүлэлтүүдийг бүс нутгаар харьцуулсан нь



ДҮГНЭЛТ

1. Энэхүү угтвар судалгааны явцад I-XI дүгээр ангийн сурагчдын авьяасыг судлах зориулалт бүхий хүүхэд, багш, эцэг эхчүүдэд зориулсан судалгааны иж бүрэн арга зүйн сантай болох эхлэл тавигдлаа.

2. Судалгааны үр дүнг бүсчилж үзвэл баруун бүсийн хүүхдүүдийн чадамжууд ерөнхийдөө өндөр, ялангуяа хэл өгүүлэхүйн чадамж дээр суурилсан авьяас, харилцааны чадамж дээр суурилсан авьяас, логик-математикийн чадамж дээр суурилсан авьяас тус, тус илүү өндөр байна. Үүнийг бид тухайн бүс нутгийн байгаль, цаг уурын онцлогт дасан зохицох чадвар, олон ястны олон төрлийн язгуур соёлын нөлөөтэй холбоотой байх магадлалтайг цаашид нягтлан судлах нь зүйтэй гэж үзлээ.

3. Зүүн бүсийн сурагчдад хараа-орон зайн чадамж дээр суурилсан авьяас, харилцааны чадамж дээр суурилсан авьяас, логик-математикийн чадамж дээр суурилсан авьяас тус, тус илүү өндөр байна.

4. Хангайн бүсийн сурагчдад байгаль, ан амьтныг хайрлах чадамж дээр суурилсан авьяас, харилцааны чадамж дээр суурилсан авьяас, хэл өгүүлэхүйн чадамж дээр суурилсан авьяас тус, тус илүү өндөр байв.

5. Төвийн бүсийн сурагчдад харилцааны чадамж дээр суурилсан авьяас, хөдөлгөөн, тэнцвэрийн

чадамж дээр суурилсан авьяас, хараа-орон зайн чадамж дээр суурилсан чадамж тус, тус илүү өндөр байна.

6. Улаанбаатар хотын сурагчдад харилцааны чадамж дээр суурилсан авьяас, хөдөлгөөн, тэнцвэр-ийн чадамж дээр суурилсан авьяас, хараа-орон зайн чадамж дээр суурилсан чадамж тус, тус илүү өндөр байв.

7. Судалгааны дүнгээс үзэхэд нийт судлуулагчдын чадамжийн дундаж түвшин 6,6-7,7 онооны хооронд хэлбэлзэж байна. Өөрөөр хэлбэл хүүхэд нэг бүрт тухайн төрлийн чадамж дундажаас дээш түвшинд илрэв. Энэ үзүүлэлтийг бид судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн авьяас чадварын хөгжлийн ерөнхий хандлага сайн байгааг илтгэж байгаа үзүүлэлт гэж үзлээ. Ийм жигд маягийн үр дүн гарсан нь гүнзгийрүүлсэн сургалттай ангиуд болон хөгжлийн бэрхшээлтэй тусгай сургуулийн хүүхдүүдийг энэ удаагийн судалгаанд хамруулаагүйтэй холбоотой.

8. I-IX дүгээр ангийн сурагчдын чадамжийг ерөнхийд нь авч үзвэл бага ангийн сурагчдын чадамж ерөнхийдөө дунд, ахлах ангийнхаас илүү, харин дунд, ахлах анги уруугаа чадамжийн үзүүлэлтүүд буурах хандлага ажиглагдаж байна. Бага ангийн сурагчдын чадамжуудын үзүүлэлт харьцангуй жигд тогтоогдов. Эдгээр онцлог нь нэг талаас бага ангийн сурагчдын сурах сонирхол

буураагүй, багшийн арга барилд дассан, хүүхдийг бага ангид суралцах хугацаанд эцэг, эхчүүд анхаарал хандуулах нь сайн байдаг, мөн бага ангийн хүүхдийн сэтгэцийн хөгжил харьцангуй тайван жигд явагддагтай холбоотой байж болох юм. Гэхдээ энэ онцлогт нөлөөлж байгаа нөлөөллийг энэ удаагийн тандах судалгаагаар тогтоох боломжгүй байсан тул цаашид нягтлан судлах шаардлагатай.

9. Дунд ангийн сурагчдын чадамжийн үзүүлэлтүүд бага ангийн сурагчдын чадамжийн үзүүлэлттэй харьцуулахад ерөнхийдөө буурах хандлагатай, хөдлөл зүй нь илүү тодорхой ажиглагдаж байна. Хэл өгүүлэхүйн чадамж дээр суурилсан авьяас, хараа-орон зайн буюу зурах, техник, технологийн мэдрэмж дээр суурилсан авьяас, харилцааны чадамж дээр суурилсан авьяасуудын түвшин бусдаасаа дээгүүр байгаа нь нэгдүгээрт тэдний хөгжлийн онцлог тухайлбал үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааг чухалчлах, хичээлүүдийг өөрийн сонирхол, туйлшруулан үзэх үзлийн үүднээс сонирхолтой, сонирхолгүй гэх мэтээр ангилж үзэх үзэлтэй, нөгөө талаас дунд ангийн сургалтын арга, олон багшийн арга барилд дасан зохицох үйл явцад гарч байгаа эерэг болон сөрөг нөлөөтэй холбоотой байх магадлалтай.

10. Ахлах ангийн сурагчдын авьяасын бүх үзүүлэлтүүд бага,

дунд ангийн сурагчдын үзүүлэлтүүдээс харьцангуй буурах хандлагатай байна. Зөвхөн харилцаанд суурилсан авьяасын үзүүлэлт дунд ангийн сурагчдынхаас дээгүүр байв. Үүнийг бид дараах хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой байх магадлалтай гэж үзлээ. Үүнд: Өнөөгийн ахлах ангийн сурагчдын дунд өөрийгөө таних, авьяас чадварыг хөгжүүлэх, мэргэжлийн баримжаа олгох, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа хангалтгүй зохиогдож байгаа, нөгөө талаас хувь хүн тус бүрийн онцлогийг харгалзсан, суралцах хэв шинжид тулгуурласан, залуучуудын сэтгэл зүйн онцлогт тохирсон, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тасралтгүй суралцах сэдлийг өдөөж өгөхөд чиглэсэн сургалтын арга барилыг оновчтой хэрэглэж чадахгүй байгаатай холбоотой байж болох юм. Энэхүү таамгийг дараагийн шатны судалгаагаар илрүүлэн баталгаажуулсны үндсэн дээр тохирох зөвлөмж, саналуудыг гаргах хэрэгтэй гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. *Ekermann L. Basic Neuropsychology. New York, "Sage", 2005, P. 27-56.*
2. *Gardner H. Frames of Mind. The Theory of Multiple Intelligences. New York, "Basic Books", 1983, 440 p.*
3. *Lynn R. The Science of Human Diversity: A History of the Pioneer Fund. New York, "University Press of America", 2001, 58-72.*
4. *Теплов Б.М. Избранные труды. Т. I, М., Издательство "Педагогика", 1985, С. 15-38.*

5. Шадриков В.Д. Вопросы психологической теории способностей // Психология. Журнал Высшей школы экономики. 2010, Т. 7, № 3, С. 41-56.